

JOHN R. COLEMAN

(Орчуулсан)  
М.Батбаатар

МУИС-ийн Социологи нийгмийн ажлын тэнхмийн багш

А.Энхбат

Нийгмийн ажилтан

## ТЭНҮҮЛЧИЙН ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ<sup>1</sup>

*...Та өөрийгөө орон гэргүй байна гэж төсөөлж чадах уу ? Та өөрийн гэсэн орон байр, өрөө, ядаж хэн нэгэнтэй хуваах зай ч үгүй байна гээд төсөөл дөө... Зурагттай том өрөө, халаалттай гал тогоо аль нь ч байхгүй . Хүссэн газар луугаа тэнэж шөнийг хаа өнгөрөөхөө ч мэдэхгүй, өдөр нь бас л хоосон орон зай, хийх ажилгүй , чиний тухай хэн ч бодохгүй.*

*Ийм амьдралыг бидний нийгмийн нэгэн хэсэг туулсаар байна. Орчин үеийн нийгмийн орхигдогсод, эд баялаг хөөсөн соёлжсон уралдаанаас хожигдогсод. Бусдын л адил коллежийн захирал Коульмэн энэ хүмүүсийг гудманд олонтаа харсан. Бусдын л адил тэрээр эдгээр хүмүүсийн амьдрал ямар байдаг бол гэж гайхдаг байлаа. Гэхдээ бусдаас ялгаатай нь энэ хүн тэрхүү ертөнцийг өөрийн биеэр судлахаар нэвтрэн орсон юм. Тэрбээр өөрийн дунд ангийн тохилог амьдралаа орхин гудамжны хүмүүстэй нэгдэжээ.*

### Лхагва гараг, 1/19

Яагаад ч юм 12 градус миний бодсоноос сэрүүн байлаа. Би өөрийгөө хүйтний эсрэг дархлаатай гэж боддог байсан ч Пенний буудлын хоосон гудманд зогсоод ирэх 10 өдрийг тэнүүлчийн амьдралаар өнгөрөөнө гэж бодоход энэ дархлаа хийсэн алга болов.

Юуны өмнө миний өмссөн хувцаснууд энэ ажилд тохирохгүй байв. Би “шинэ” хувцаснууд дахь үстэй цамц , сунасан светер уранхай өмд , малгай ороолтоо өмнөх өдөр нь Хьюстон дахь гудамжнаас 19 доллараар авсан . Худалдагч “ Танд шинэ гутал хэрэггүй , одоо байгаа чинь орон гэргүйчүүдэд тохирно” гэж хэлсэн нь миний сэтгэлийг бага зэрэг өвтгөсөн байж болох. Учир нь энэхүү гутлыг би ажилдаа өмсдөг байлаа.

Хувцсаа Пенний буудал дээр солиод би гудманд гарахад бэлэн болсон, эсвэл тэгж бодож байлаа. Намайг гарахад хүмүүс тэс өөрөөр ч хараад байх шиг. 40 гарсан гялалзаж яваа эрчүүд намайг хараад гайхаж буй нь мэдрэгдэж байв. 7-р өргөн чөлөө 35-р гудманд би Кофены мухлаг руу орлоо. Худалдагч намайг анхааралтай хараад 99 центийн өглөөний цай /татвар нэмэгдэнэ/ захирад эхлээд тооцоогоо хийхийг хүслээ. Би үүнийг төлсөн / Юмыг яаж мэдэх вэ гээд би халаасандаа 40 доллартай гарсан юм/ гэхдээ надаас бусад нь гарахдаа тооцоогоо хийж байгааг ажиг амжсан юм.

9.30 гэхэд би хогийн савнаас Таймс олж уншиж, буудал хавьцаа гудмаар эргэлдэж, Хурлын төвийн барилгын ажлыг хэсэг харлаа . Энд хийгээд байх юм нэг их харагдахгүй байв. Дараа нь би эв нэгдлийн талбай дээр хар тамхины наймаа өрнөхийг харсан. Тэгээд 14-р гудамжны орлого нэмэгдүүлэх төв дээр очиж хүмүүс эд баялгийн төлөө зүдэрч байхыг харчихаад Хьюстоны гудманд зогсож машин тооллоо. Би “ **Зүгээр суух нь хийх ажил ихтэй үед л сайхан байдаг**” гэдэг үгийг дотроо бодсон нь дулаацахад дөхөм болов. Өөрийн адил

<sup>1</sup> Социологичдын унших бичиг, ширээний ном болсон Ж.Хенслиний “Социологийн ертөнцөд аялахуй” бүтээлээс зохиогч Ж.Коульмений “Тэнүүлчийн өдрийн тэмдэглэл” өгүүллийг шавь А.Энхбат орчуулсныг хянан үзээд уншигч танаа толилуулж байна. Орчуулгын алдаа мадаг бий эсэхийг уншигч та мэргэн оюундаа тунгаан хэрэв буй аваас эерүүлэн уншихыг хичээнгүйлэн хүсэж байна. Хянан нягталсан: Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш М.Батбаатар

бусад тэнэмэлүүдийг ажиг цаг надад хангалттай байв. Тэдний ихэнх нь жирийн хүмүүсийн адил намайг анзаарахгүй байсан юм.

Портын захиргааны автобусны буудал дээр Ховард гэх нэгэн эр байлаа. Тэрээр магадгүй надтай нэг үеийнх боловч цаг хугацаа түүний нүүрэн дээр гүн үрчлээс үлдээжээ. “Зун цаг ирэхэд бүх юм өөр болно. Би машин авч далайн эрэг рүү явна. Мөн 6 нимбэг аваад баахан нимбэгийн ундаа хийж аваад машинаараа зугаална” гэж тэрээр хэллээ.

Улс орон бүхэлдээ нэг хүн оргилд нь байна гэсэн бодлоор дэндүү хол явсан бололтой. Энгийн жишээ бол төрсөн өдөр. Энэ баяраар хэн бялууны лааг үлээдэг билээ? Нэг л хүн. Хэрэв бид ямар нэг юм өөрчлөхийг хүсч л байгаа бол төрсөн өдрийн бялуунаас эхлэх хэрэгтэй юм шиг.

Бидэн шиг хүмүүст ажил хийх боломж байдаг болов уу?

“Ажил гэдэг чинь амьдрах хүсэлтэй залуу хүмүүсийн зүйл. Харин бидэнд юу ч байхгүй. Би ажлын тухай мөрөөдөхөө болиод удаж байна. Одоо би нимбэгийн ундаа бас машин мөрөөддөг. “ гэж Ховард хэлсэн юм. “Архи, хар тамхи” тэнүүлчдийн амьдралд элбэг ажээ. Эдний учруулсан хохирол гудамжны бараг бүх хүмүүсийн нүүрэн дээр илхэн байна.

Миний тэнүүлчлэл ямар ч зорилгогүй байв. Төлөвлөгөө, ашиг, шалтгаан гэх зүйлийн аль нь ч байсангүй. Ямар ч хэрэггүй мэт цаг хугацаа урссаар. Би өөрийгөө үүнийг яагаад хийж байгаагаа ч сайн мэдэхгүй л байлаа.

Би далд газар олоод тэндээ сонин дэвсээд хэвтлээ. Хэр удаан унтсанаа санахгүй байна? Магадгүй, нэг их удаагүй байх. Би нэгэн хурц гэрлээс болж сэрсэн юм. Тэрээр надаа “Чи энд унтаж болохгүй, уучлаарай чи эндээс гарах хэрэгтэй” гэж хэллээ. Би “Уучлаарай” гэдэг үгийг сонсоно гэж санасангүй энэ үг надад сэтгэл хөдөлгөм сонсогдов. Би босоод 47-р гудамж руу явлаа тэгээд 5-р Мэдисоны өргөн чөлөөний явган хүний зам руу очсон юм. Тэнд дулаахан гэдгийг би мэддэг байсан (Учир нь тэр газраар би ажил руугаа явдаг). Тэнд аль хэдийнээ нэг хүн эзэгнэсэн байсан ч 2 хүн багтахаар байв, тэр хүн надад зай гаргаж өглөө.

### **Пүрэв гараг, 1/20**

Чи гудманд амьдарвал, өглөө болсныг том ачааны машины явах дуугаар мэддэг юм. Хогны машинаас өөр, талх сүүний ч юмуу машин явж эхэлбэл чи шөнө дууссаныг мэдэж болно. Би Пенний буудал руу буцаж угаалгын өрөөнд нь нүүр гараа угаалаа. Би болон тэнд байсан хүмүүсийг хараад ямар ч эрүүл мэндийн ажилтны сэтгэл нь хөдлөхөөр байв. Энэ хүмүүсийн гаднаас л харахад бидний дундаас хамгийн зарчим ч нөхөд энд байгааг олж үзэж болохоор байв.

Би кофе аваад төв замын буудал дээр уухаар гарлаа. Гэвч азгүйгэж, цагдаа намайг олж хараад тэндээс гарч кофегоо гадаа уухыг шаардлаа. Өглөөний цайны (1,31 доллараар Бимплигээс авсан) дараа би нийтийн номын сан нээгдтэл гадуур сэлгүүцэв. Би уранхай Таймс олж үзэхэд өчигдөр шөнө бид энэ жилийн хамгийн хүйтэн шөнийг давсан бөгөөд хотод 4365 хүн дэн буудалд хоног төөрүүлснийг мэдлээ. Номын сангийн хувьд надад сайхан байлаа. Хүмүүс надтай хуучин костюмаа өмсөх мэт харьцаж байв. Цаг өнгөрөөхийн тулд би 50 жилийн өмнөх хотын халамжийн мэдээллийг уншлаа. 1933 онд хотод тэнүүлчдэд зориулсан 4524 ор байсан бөгөөд шөнө бүр тиг дүүрдэг байсан гэж бичжээ. 1983 он гэхэд юмс тайлбарлагдашгүй болжээ. Тэнд бичсэнээр тэр үеийн халамжийн байгууллагын даргаар Мэннинг гэх хүн байсан бөгөөд тэрээр ирээдүйн төлөө их санаа зовоогүй бололтой.

Би өөрийгөө өөрчлөгдөж буйг мэдэрч байв. Гэрлэн дохиог анзаарахаа больж алхаа маань удааширсан байна. Гэхдээ л үе үе бугуйндааа байхгүй цагаа байн байн хяламхийгээд байлаа, цаг байсан ч юу ч өөрчлөгдөхгүй юм. *Термометрын заалт тэр үед надад ямар ч цагаас илүү чухал болсон байсан юм . . .*

Өдөртөө цаг агаар дулаарч байсан ч байн байн температур өөрчлөгдөн хүссэнээс зөрөх аж. Оройн 9 цагийн үед би дулаахан 47-р гудам руугаа буцан алхлаа. Өчигдөр шөнө байсан эр аль хэдийнээ байраа эзлэн тухалжээ. Тэр надад зай гаргаж тавьсан нь илхэн байв.

Би түүнээс гудманд хэр удаж байгааг асуув.

“ 11 жил одоо 12 дахь жилдээ орж байна” гэлээ.

“ Энэ миний 2 дахь шөнө”

“Чи энд удаан гэсч чадахгүй ч байж магад энэ бол хэн бүхний даваад гардаг зүйл биш”

“Та ер нь хоргодох байр луу явдаг уу?”

“Би түүнийг чинь тэсдэггүй юм . Би эндэхийг хэзээд илүү үзнэ. “

### **Баасан гараг, 1/21**

Нар мандахаас өмнө намайг явахад – тэрээр надад хандан амжилт хүслээ. Би түүн рүү хариу болгож гараа даллахад тэр ч хариу барьялаа. Манхэттэний гудмаар өглөө эрт явахад чамд

дахин боловсруулалт, хог хаягдал тээвэрлэлт нь энэ хотын хамгийн том үйлдвэрлэл мэт санагдана. Миний олсон хамгийн сайхан зүйл гэвэл хөлөнд минь унтахад яг таарсан даавуун цүнх байв. Би өдрийн хэмнэлтэй болж байлаа. Буудал дээр нүүр гараа угаана, дараа нь гудманд кофегоо ууна, Блимпид өглөөний унд, тэгээд Таймс хайж хогийн сав ухах, дараа нь паркад нөгөөхөө тайван унших гэхчлэн.

Зарим өдөр илүү азтай байх нь бий. Өнөөдөр гэхэд би утасний бүхээгнээс 20 цент олж 9, 10-р гудамжны дунд 6-р өргөн чөлөөнд Бахын хөгжмийг залуу лимбэчин хэрхэн тоглохыг сонслоо. Олон хүн залуу бүсгүйг үл тоомсорлож байлаа, зарим нь бүр түүний лимбэний цүнх дээгүүр хээвнэг алхалж байв. Цөөхөн, задгай мөнгө өгч буй хүмүүс санаа зовсон, хүний анхаарал татахгүйг хичээсэн шинжтэй харагдаж байв. Шөнө болоход дахиад л хүйтрээд эхэллээ. Би 47-р гудам руу очиход хөрш маань алга байлаа. Тэндхийг халаагаагүй байв. Тэд халаалтыг баасан гаригт хаадаг юм бол уу? Ер нь тэнүүлчид бидэнд эрх гэж байдаггүй юм гэж үү?

Баруун хойшоо 33-р гудамжны 8-р өргөн чөлөөнд хаалттай, засварт орсон орц байв. Би картон цаас нөмрөн хөлөө атирч хэвтлээ. Гэнэт хэн нэгэн картоныг сөхөж би сэрлээ.

- “Чи миний хамтрагчийг харж байгаа биз дээ. Чи бидэнд мөнгө өгөх хэрэгтэй!”
- Би нойрмогоор “надад юу ч байхгүй”
- “Чамд ямар нэг зүйл байх ёстой хөгшөөн”
- Хэрвээ байсан бол би энд унтаж байх уу? “

Түүний хамтрагч нь “Аливээ наад хөгшин новшоо орхи. Наадах чинь хэрэггүй амьтан байна.” гэлээ.

- “Энэнд юм байгаа. Босоод тэрийгээ өг.”

Би босоод халаасаа уудалж эхлэв. Тэр хоёр хоёулаа миний зүүн талд зогсож байв. Энэ миний боломж байсан юм. Би гэнэт хөдлөн 33-р гудамжнаас 9-р өргөн чөлөө рүү гүйлээ. Тэд араас хөөсөнгүй. Энэ нь ч сайн хэрэг болсон юм учир нь би уралдахад дэндүү даарсан, нөгөөтэйгүүр хөл хөшсөн байлаа.

### **Бямба гараг, 1/22**

29-р гудамжинд явган суух нэгэн эр үнэнийг хэллээ. Хамгийн чухал нь дулаахан унтаж болох газартай байх. Мөн чамайг халамжлах хэн нэгэн байвал бүр чухал.

Тэрээр нэг хөлөө цаасаар ороогоод улаан туузаар чимсэн байсан ч бороонд тэр нь нурууд яах гэж ингэснийг мэдэхийн аргагүй байв.

Би бараг унтсангүй маргаашийн цаг агаарын мэдээ их бороо орохыг хэлж байв. Тиймээс яагаад шөнө дуусахыг хүснэ гэж. Өглөөний сонин, хотын дарга Коч орон гэргүйчүүдэд илүү анхаарах болсныг бичжээ.

Гэхдээ тэр юу хийж чадах юм бэ? Тэр эр Нью-Йоркийн тэнүүлчдэд туслах тусам тэдний тоо илүү өснө гэдэгт санаа зовох хэрэгтэй. Мэдисоны цэнгэлдэхэд болж буй Вольво теннисний тэмцээнд орж гарч буй хүмүүс “тэнүүлчин” тэдний хажууд байхад хичнээн тухгүй байгааг би анзаарч байлаа. Хийсвэрээр төсөөлөх сайхан ч бодитоор бол тийм ч сайхан бишээ. Төмөр замын цагдаа нар биднийг харвал хөөх тушаалтайг харахад үүнийг гайхаад байх зүйл алга.

Магадгүй бид бол “бие хүн” биш. Бид хэн ч мэдэхгүй хүмүүс. Гудманд гарснаас өмнөх амьдралдаа таних гурван ч хүнтэйгээ таарлаа. Хэн нь ч намайг таньсангүй. Нэг нь Артур Андэрсон энд Компаний ерөнхий байцаагч, нөгөөх нь 2-р цагдаагийн хүчний олон долоо хоног хамт бэлтгэл хийсэн дэслэгч, гуравдах нь миний амьдардаг байрыг эзэмшигч байлаа . . .

Орой нилээн эрт би 7-р өргөн чөлөөний гадна цэцэрлэгт унтлаа. Хоёр мотоцикльтой цагдаа ирээд намайг сэрээж сайн чанарын гэмээр 2 цүнх минийх мөн эсэхийг шалгааж гарав. Би тэдгээрийг урьд хэзээ ч харж байгаагүй гэж хэллээ. Нэг цагдаа намайг худлаа ярьж байгаа гэдэгт итгэлтэй байв. Гэвч нэгэн хар арьст эр гарч ирээд тэдгээр цүнх түүний найзынх гэлээ. Эдгээр цагдаа нарын яарсан байрын асуулга надад ямарваа нэг нөхөн төлбөр өгөхгүй гэдэг нь ойлгомжтой байсан юм. Гуравдагч цагдаа газраас олсон зүйлсийг нэгтгэн нөхцөл байдлыг дүгнэхийг хичээж байжээ. Тэр эр гарч ирэхэд бүх зүйл дуусч, эзэн нь цүнхээ авсан юм. Би буцаад унтахаар хэвтлээ. Хэдэн цагийн дараа сэрэхэд хар арьст эр байсан газраа л зогсож байсан бөгөөд наймаагаа ч хийсээр байв.

### **Ням гараг, 1/23**

Хуурай сэрүүн байдал. Үүнийг бороотой өдөр мэдрэх нь : Стэйт айландын гаталга хөлөг онгоц дээр л боломжтой юм.

25 мөнгөөр би эргийг 4 удаа гаталж, олсон Таймс сониноос хүссэн бүх зүйлийг уншиж, үгийн сүлжээг нь бөглөж дууслаа.

Би теннисний тэмцээн дуусах дөхсөн цэцэрлэг рүү дөхөхөд цагдаа нар хүмүүс бөөгнөрөх үед биднийг хол байлгах тал дээр гойд анхаарч байгааг харлаа. Нэг настай эмэгтэй тэдэнд хөөгдсөндөө тун сэтгэл дундуур байв. “Чи миний сексийн амьдралыг сүйрүүлж байна. Чи миний сексийн амьдралыг сүйрүүлж байна. Чи сонсож байна уу?” гэж хашгична. Нэг залуу хатагтай над дээр ирж намайг хайр дурлалаа хайж байгаа эсэхийг асуулаа. “Үгүй хатагтай би борооноос хоргодох гэж хичээж байна.” . . .

Дахиад л нөгөө засвар хийгдэж буй орц руугаа явлаа. Учир нь 47-р гудамжинд халаалт ирээгүй л байв. Шөнө маш хүйтэн байв. Унтах гэж оролдоход бие минь хэсэг хэсгээрээ өвдөж байлаа. Хэвтэж байхдаа эргэх нь маш хэцүү ажил байлаа. Энэ нь зөвхөн картон маань норчихсон урагдах гээд байгаагаас бус бие хэсэг хэсгээрээ хөлдөж өөр хэн нэгэнд харьяалагдах болсон мэт санагдманаас ямар ч гайхамшигт зүйл байсан энэхүү манан буданг хүчит гэрлээрээ арилгахыг би хүсч байсан юм. Гэхдээ миний найдаж байсан гайхамшигт зүйл бол хүлээх ёстой байлаа.

#### *Даваа гараг, 1/24*

Энэ өглөө би 14-р гудамжинд байрлах ажил олгох албанд очиж ямар нэг өдрийн ажил олж болох талаар асуулаа. Энэ албан газарт хүн хөдөлгөөн бага харагдах бөгөөд, байгаа ажил нь муу нөхцөлтэй бага цалинтай ажлууд аж.

Би нэг ярилцлаганд ороод аяга таваг угаагчийн ажил оллоо гэж бодсон ч нэг зүйлийг мартжээ. Надад бичиг баримт алга. Бичиг баримт байхгүй бол ажил байхгүй.

Брайнтын хүрээлэнд нэг настай эмэгтэй энэ өглөө тун сонирхолтой зүйлийг ярьлаа. 10 минутын турш нэг ч завсаргүй ярьж тэрээр энэ нийгмийн доголдлыг нэгийг нь ч гээлгүй дүгнэлээ. Цэцэрлэгийн ариун цэврийн өрөө цоожтой байдаг талаар гомдоллон эхэлж, Ирландууд хэдий хүчтэй ч бусдаас илүү 00 хэрэг болдог, Англичууд Еврейчүүдийн сул талууд, тэжээвэр шувууны зах зээлд цацагт хяруул тэжээхийн давуу тал, Элэанор Рүзвэлтээс болж бид дэлхийн II дайнд орох болсон тухай, цэцэрлэгт зардаг зайдас, Оросын хөгийн хиймэл дагуул Энэтхэгийн далайд унасан нь Шенаниганы (1964-1965 онд АНУ-д гарч байсан хүүхдийн телевизийн хошин шоу) жишээ гэлээ. Мөн Оросууд болон Уэлсийн гүнж Диана нар холбоотой бөгөөд хуйвалдан сургуульд номлогч мөргөлчдийг байлгахыг хориглодог байна. Гэхдээ тэр хөөрхий Протестант сайдууд юу хийж чадах юм бэ? Хүүхдүүд жинхэнэ шашны хүмүүжлийг сургуулиасаа авдагтай адил бид түүнийг нь гэлэнмаа нараас авч болох юм. Бурхан тэднийг ивээг?

Ядаж энэ үг тэрхүү эмэгтэйн гол санаа байсан байх. Гэхдээ магадгүй би бусад зүйлийг нь орхигдуулсан байж болох юм.

Өдрийн 3,30-д би илүү хүйтрэхийг мэдээд зүүн 3-р гудамжинд байрлах эрэгтэйчүүдийн орогнох байрыг зорилоо. Энэ бол тусламж эрж буй эрчүүдийн гол очих газар юм. Энэ газар 1300 хүнийг хооллож заримд нь хонох байр хүртэл гаргаж өгдөг. Надад хүмүүс эндээс унтах ор олох боломж хамгийн их бөгөөд хооллож болох газар гэж хэлсэн юм.

Би Лондоны ажилчдын байрны болон хоргодох газрын Чарльз Дикенсийн үеийн уран зургуудыг харж байсан. Харин одоо би түүнтэй адил төрхийг ХХ зууны сүүлийн жилүүдэд дэлхийн хамгийн агуу хотод харж байна. Хүлээлгийн өрөөнд олон эрс янз бүрээр зогсож, хэвтэж, сууж, суниаж хүлээж байв. Энэ нь яг л төрөл бүрийн сүнсний цуглуулга шиг байв. Энэ хот хүссэн хэн бүхнийг хүлээн авахаа амална. Өөр хаа нэг газарт ад болсон бол өөрийн байраа зүүн 3-р гудамжинд олж болох ажээ. Амьсгалах агаар энэ газарт нэн хүнд бөгөөд хурц ажээ. Архи, шээс, нялуун болон никотин марихуаны үнэр хамар сэтлэм байна. 3 юмуу 4 хүний нөөцийн байгууллагын цагдаагийн офицерууд энд хүчирхийллийг аль болох боломжтой хэмжээнд барихыг хичээж байв.

Удаан хүлээсний эцэст хооллох тасалбараа аваад дараа ирж хоног өнгөрөөх тасалбараа аваарай гэлээ.

Одоо хоолоо идэхийн тулд жагсах хэрэгтэй боллоо. Би энд байгаа хүмүүсийн бөөгнөрлийг малын хашаан дахь үхэр сүрэгтэй адилтгаж болмоор санагдлаа. Жагсаал хүлээлгийн өрөөний 2 ханыг пиг дүүргэсэн байлаа. Чанга яригчтай нэг эр бидэнд байнга эгнээндээ зогсохыг сануулан хашгирах аж. Нэг өтөл болоод салганасан /эсвэл согтуу/ хүн хөл дээрээ тогтож чадахгүй байв. Тэрээр хүний тусламжтай сандал дээр сууж түүн дээрээсээ ч уналаа. Чанга яригчтай хүн түүнд туслах талаар юу ч хийгээгүй ба бид ч бас хэсэг харж байгаад оройн хоолны тухай бодолдоо эргэн орлоо.

Би өрөөнд байгаа хүмүүсийг хараад тэдний гадаад төрх, хөдөлгөөн зэргээс нь товч ерөнхий яаруу дүгнэлтийг гаргалаа. Миний бодлоор энд байгаа хүмүүсийн ¼ нь ажил хийх

бүрэн боломжтой байлаа. Эдгээр хүмүүс бидний инфляцийн эсрэг дайнд сайн дураараа орж ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн хүмүүс шиг харагдана. Удаах ¼ нь зарим нэг тусламж зөвлөгөө бие хүн болоход туслах арга хэмжээ авсны дараа ажиллаж болохоор харагдана. Гэхдээ үлдсэн хагас нь өвчин, дутагдал зовлонгоос болж туйлдаа хүрсэн харагдах бөгөөд тэднийг энд нийгмийн туслалцаа авч байгаагаас өөрөөр харахад хэцүү байлаа.

Тохирсон цагийн дагуу бид 20-30 хүний бүлэгт хуваагдан хооллох заал руу орлоо. Чанга яригчтай эр тэнд бас л байсан бөгөөд бүгдийг удирдан цахилгаан багажийн хүчийг тултал нь ашиглах ажээ. Тэрээр биднийг бөөнөөр нь болон тус тусад нь завсарлагаагүй доромжилсоор байсан бөгөөд, түүний үгсийн сангийн мэдлэг хомсоос 4 үсэгтэй танил хараалыг байн байн урсгах аж.

Түүний над руу дайрсан хамгийн хурц довтолгоо намайг хоолоо авахдаа удсанаас болж ирсэн юм. Тэр миний цагаан арьст өвөг дээдсийн дутагталтай талыг хэлж, намайг гайхашруулсан юм.

Бид хоолоо авсан ч гэлээ түүний орилох зогссонгүй. Дахин дахин бидэнд хурдан идээд зайлахыг сануулж байлаа. Хооллолт магадгүй 6 минут үргэлжилсэн байх.

Дээд давхарт албаны хүмүүс Бруклин дэх орогнох байр луу явах хүмүүсийг зохицуулж байлаа. Зарим нэг сайн дурын ажилчид байсан нь намайг баярлуулж байлаа.

Хоргодох газрын тасалбар авахаар жагсаж байх үед гэнэт зодоон өрнөлөө. Нэг эр цувнаасаа хутга гаргахад нөгөөх нь зугатлаа, удалгүй цагдаа нар ирж хутгатай хүнийг тэндээс холдууллаа. Зодоон янз нь жагсаал дахь байрлалаас болсон бололтой. Тэнд биднийг зохион байгуулахад хангалттай сайн дурынхан байгаагүй тул тэд их буугаа гаргалаа “Ноён чанга яригч” тэрээр “Одоо намайг сонсоцгоо. Энд Вашингтон.ФТ (бас нэг хоргодох газар) орох хангалттай олон автобус алга тиймээс нойр авахыг хүсч байвал Бруклин рүү явцгаа. Ямар ч асуулт асуух хэрэггүй. Дуугүй сонс. Та нар ер нь хүний хэлснийг сонсоогүйгээс ийм газар ингээд байж байгаа юм. “ Гэвч би тасалбараа авсан ч Бруклин ороод хаа хонох талаар асуухаар шийдлээ. Тэрээр над руу хараад чанга яригчийн бүхий л хүчин чадлыг ашиглан “ Битгий асуулт асуу гэж би хэлсэн. Чи хэн ч биш биз дээ. “

Тасалбар түгээх цонхонд ойртохыг хүлээсээр л байв. Албаны 3 ажилтан гайхалтай эелдэг байсан ба энэ нь ч үр дүнгээ өгч байв. Дөрөв дэх ажилтны эр эмийн алин болохыг мэдэж чадаагүй бөгөөд тэрээр огт хөдлөхгүй мэт харагдана. Тэдний удирдагч болов уу гэмээр нэг хүн биднээс энд ингэж хүлээлгэх болсонд байн байн хүлцэл эрэх ажээ. 23.30-д бид хүлээлгийн өрөөнд дахин орсон байсан бөгөөд энэ удаа автобусаа хүлээж байв. Шинэ дарга тэнд гараад ирлээ. Тэрээр ноён чанга яригч шиг анхаарлыг өөртөө татаж чадлаа. Тэдний шинэ хүн бүр олиггүй байсан юм. Тэрээр биднийг бөөгнөрүүлээд дараа нь буцаан урт эгнээнд оруулж жагсаана. Бид энэ хөдөлгөөнийг хэд дахин давтаж хийсэн юм . . .

Төлөвлөсөн цагаас нилээд хожим цуваа хөдөллөө. Бид сургуулийн автобусаар 168-р гудамжны ФТ.Вашингтоны өргөн чөлөөнд очлоо. Тэнд ойролцоогоор 2.30-н үед цагдаа, нийгмийн ажилтнууд, хувийн хамгаалалт угтан авлаа. Тэд биднийг шүршүүрт оруулж (дуртай яа) цэвэрхэн дотуур хувцас өгөөд дээд давхар луу хөл бөмбөгийн талбай шиг том зааланд засаж янзалсан тухтай орнууд руу явуулсан юм. Тэнд бид 530-лаа байсан бөгөөд цөм удалгүй нойрондоо дийлдэн дугжирлаа.

### *Мягмар гараг, 1/25*

Бид өглөөний 6 цагт шүгэл, орилолдооноор сэрлээ, биднийг босч аль болох хурдан Манхэттэн рүү буцахыг тушаав. Буцан зүүн 3-р гудамжинд ирэхэд энэ хотод байж болох хамгийн муу дарга маань тэнд байсангүй. Тиймээс би өглөөний хоол оройныхоос арай чимээгүй болж болох юм гэж бодов. 8 цаг гэхэд би 3 сонирхолтой үйл явдлыг харлаа. Миний чанх урд зогсож байсан хүн гэнэт хажуудаа байсан сандал авч хэн нэгний толгой руу цохих гэж оролдов . Би замаас нь холдох гэж байгаад хэвтэж байсан хөгшний дээрээс уналаа. Хэсэг орилолдооны эцэст зодоон дуусч өнөөх хөгшин намайг уучиллаа.

Хооллох заал руу орох үед залуу эр над руу сексийн хандлагаа илэрхийллээ. Намайг түүнээс холдон маш эвгүйцэн дэмий л цувныхаа халаасыг тэмтрэхэд тэрээр намайг зэвсэг гаргах нь гэж боджээ. Залуу намайг хананд шахаад миний халаасыг нэгжсэн юм, тэнд юу ч байсангүй.

Би зүүн 3-р гудамжны барилгаас гарч байх үед хүний нөөцийн удирдлагын хоёр хар арьст цагдаа, хоёр залуу хар арьстныг авчирч байлаа. Нэг офицер залууг шилдэж явахад, нөгөөх нь гарыг нь ард нь гаргаж гавласан байх ба өгзөг рүү нь дахин дахин өшиглөх ажээ.

Миний тэнүүлчлэл өнөөдөр илүү зорилгогүй болсон байв. Би зүүн 3-р гудамжинд болсон үйл явдлыг бодсоор л байлаа. Тэндхийн үйл ажиллагааг яаж илүү сайжруулж болох вэ? Хэрэв би тэндхийн ажилтан байсан бол тэнд болж байгаа үйл явдлын бас л нэг хэсэг нь болох болов уу? Эсвэл би аль болох бага зүйл хийж мөн төдий чинээ бага зүйл бодох юм болов уу? Өдөр өнгөрөхөд би өнөөдөр юу хийж барснаа сайн мэдэхгүй л байв. Зөвхөн ганцаардсан, тусгаарлагдсан хором мөчүүдийг л өнгөрөөж байлаа.. Жишээ нь: Мэдисоны өргөн чөлөөний хажууханд байх дэлгүүрийн шилэн цонхны цаана харагдах болор мөнгөн эдлэлүүдийг хараад энэ миний харж байгаа зүйл өчигдөр цуг шөнийг барсан хүмүүст юу бодогдуулдаг бол ?

Хэтэрхий хурдан буцаж хоргодох байрандаа очиж хооллож, унтах цаг ирлээ. Эхэндээ надад үүнийг дахин хийх тэнхээ байхгүй гэж бодож байлаа. Ер нь тэдний хэрэгцээг судлахын тулд заавал хэн нэгэн үүнийг хийх хэрэгтэй гэж үү ? Би “Одоо хангалттай. Надад харах өөр олон зүйл бий” гэж орилмоор санагдаж байлаа. Гэвч би дахин тийшээ очлоо учир нь тэнд очихгүй байх нь очихоос илүү их хүч чадал шаардах байв.

Оройн хоолны цувааны үед миний ард зогсох эр энэ газрын талаар нэгэн үнэн үгийг хэлсэн юм. **“ Би хэзээ ч там ийм өнгөөр бидэн дээр ирнэ гэж бодсонгүй”**

Би энэ шөнө илүү азтай байлаа. Сайх шөнө Уард Айландын Кийнэр барилгыг сугалсан бөгөөд энэ газар 416 хүний багтаамжтай байв. Барилга хуучирч муудсан бөгөөд эндхийн агаар эмнэлгийнх шиг ажээ. Гэхдээ ажилтнууд нь эелдэг, өрөө нь тийм ч их хүнгүй / 326-р өрөөнд 12 л ор байв./

Ор бүр цагаан даавуутай цэвэр, 00 өрөө нь ариун цэврийн цаастай байлаа. Энд хэмжээ хязгаар, харуул, дутагдалтай байсан ч эмх цэгцтэй байсан бөгөөд би энд ядаж л хамаг нэр төрөө алдсан мэт санагдахгүй байв.

#### *Лхагва гараг, 1/26*

. . . Зүүн 3-р гудамжны хоргодох газар луу оройн хоолондоо буцаад зүглэв.

Энэ мөчийг хойшлуулах хүсэл минь надад утгагүй ч юм шиг санагдана. Гэхдээ тэндхийн хоол нь муугүй, барилга нь халаалттай тиймээс бас тийм ч муу бишээ. Тэнд өгөх цорын ганц хоолны багаж нь хуванцар халбага. Хэд оролдсоны дараа та үүгээр маслаа талхан дээрээ түрхэж сурна. Хэрэв танд элэг эсвэл хиам таарвал түүнийг зүсэх хэрэггүй зүгээр л хоёр талхны хооронд хийгээд зажил . Бусад бүх хоолнуудыг халбагаар идэж болох ажээ. Мөн хоолны дараа кофе шимэх биш залгилах нь тийм ч сайхан биш юм. Эндхийн хамгийн хэцүү нь идэх гэж цуваанд ороход үл ойлгогдох ширэнгэн ой шиг болдог байлаа. Минут бүрд нэг тэсрэлт болж байгаа мэт. Хэн нэгэн нөгөөгийнхөө урдуур нь орох гэж зүтгэнэ, хэн нэгэн санмсаргүйгээр бусдын хөл дээр гишгэнэ. Тэгээд л адал явдал цааш үргэлжлэх ажээ.

Энд байгаа хүмүүсээс хамгийн сүрдмээр нь маш ууртай олон олон залуу харууд юм. Үзэн ядалт тэдний үг бүрт шингэсэн байх агаад заримын нь үйл хөдлөлөөр илэрнэ. Би тэдний яагаад ийм ууртай догшин болсныг тун удаан төсөөлж чадахгүй байлаа. Гэхдээ би эндхийн удирдагч, ноён чанга яригч байсан бол тэднийг энэ их уур уцаараас яаж салгахаа мэдэхгүй байх байсан юм. Энд зуу зуун хүн хар тамхи, архианаас болж сүйджээ. Илүү цөөн гэхдээ харамсмаар тооны хүмүүс үзэн ядалтад автаж, түүндээ дийлдсэн харагдана. Тэдний хэлдэг хамгийн гол тэдний хоолойг чангаар дуугаргадаг үг бол “ Намайг хүндэл хөгшөөн”. Ерөнхий төрх бол хэн нэгэн эсвэл ямар нэг бүлэг, бусдыгаа доош нь хийх, тэднийг доромжлох, тэдний үл зөвшөөрөх хэв заншлыг дагуулах гэж оролдох, хэн нэгний замд саад болох зэрэг байна. Тиймээс ихэнхи зодоон хэн нэгний орон зайд халдсанаас болдог байв. Энэхүү орон зай нь цуваан дахь байр, эзэмшдэг булан гэх зэрэг юм.

Өнөөдөр би Брүклэн орох автобус хамгийн эрт хөдлөх байх гэж бодоод түүнийг сонголоо. Эндэх байр нь хуучин сургууль байсан бөгөөд Уиллиамсийн өргөн чөлөөнд байдаг, 400 ортой ажээ. Бид маш эрт хөдөлсөн боловч 11 цаг хүртэл хүн оруулдаггүй тул тэр хүртэл хүлээх боллоо.

10 цагийн үед нэгэн эр бидэн шиг олон шинэ хүмүүсийг туусаар булан руу аваачлаа. Бидэн шиг хөгшин, эрүүл мэнд муутай, бага үндэстнүүд түүний хэлснийг үг дуугүй хийх нь бусдад үлгэр жишээ болж байлаа. Зөвхөн шөнө дундын үед албаны хүмүүс ирэхэд тэр эр зохион байгуулагч биш жүжигчин болохыг бид мэдэв.

#### *Пүрэв гараг, 1/27*

Өглөө дахиад гудамжиндаа. Өнөөдөр ийм замаар амьдрах цаг хичнээн бага үлдсэнийг би саналаа. Дахиад хийх юм надад маш их харин цаг бага мэт санагдана.

Миний нэг хэсэг намайг бүхлээрээ энэ ертөнцийн хэсэг болсон гэж хэлэх ажээ. Би удаан алхаж мөрөө унжийлгадаг болсноо мэдэж байлаа . . . Би цэвэр байх талаар илүү санаа зовох боллоо.

Гэхдээ би гэнэт өөрийнхөө ямар тэнэг болохыг ухаарсан юм. Энэ бүхэн маргааш дуусч би хэзээ ч хүссэн үүнээс салж чадна, харин 47-р гудамжны журмын нөхөр маань 11 жил ингэж суусан шүү дээ. Би энэ 11 жил юу өгүүлж чадахыг огт мэдэхгүй.

Энэ өдөр би нилээд эрт урьд нь 5 удаа хооллож байсан “Асар” гэдэг ресторан луу очлоо. Би касс дээр зогсох хүнийг танихгүй юм.

“Эндээс гар” гэж тэр хэллээ.

“Гэхдээ надад мөнгө байгаа”

“Чи намайг сонссон. Эндээс гар” Түүний хоолой илүү чанга болжээ.

“Тэр хүн намайг танина” гэж би цаана байгаа эндхийн эзний зүг харан хэллээ.

Эзэмшигч нь толгой дохиход бүртгэгч “За яахав, гэхдээ хойно суугаарай”

Хэрэв энэ гудамжны амьдрал бодитой байсан бол, би эхний “эндээс гар” гэсэн үгээр гарч намайг хөөсөн эр сэтгэл ханан хоцорч, харин би өөрийгөө хүндэтгэх хүндэтгэлээ бүрэн алдаж энд үйлчлүүлэх үнэ цэнэгүй гэж өөрийгөө дүгнэн, уруудах шат минь эхлэх биз ээ.

Одоог хүртэл би никотины хорыг ойлгоогүй явж. Хар тамхи архины хамаарал намайг тойроод удаж байна. Гэхдээ тамхи татахыг би давж гарахад амархан гэж бодож явсан юм. Эдгээр өдрүүдэд надаас, тамхи үл татагч надаас хэдэн удаа ганц янжуур гуйсан болоо? Мэдээж 100 гарна. Тамхи бол энд маш чухал. Цөөхөн хүн зүгээр өгч, зарим нэг нь ширхэгийг нь 8 центээр зарна. Одоо би хамаарал гэж юу болохыг урьдаас илүү сайн мэднэ. Өнөө шөнө би дахин Кийнэрт бүртгүүлээ. Би Бруклинээс хаширсан дахиж тийшээ очихгүй. Дээд давхарт хүлээж суухдаа би зүүн хөлөө залуу хар эрийн чанх урд нь суусан ширээн дээр тоомжиргүй тавьсан байлаа.

“Хөөш хөлөө аваач”. Би хөлөө аваад “уучлаарай” гэж хэллээ. Гэхдээ би оройтсон байлаа. Би хамгийн гол дүрмийг зөрчжээ. Би тэр эрийн орон зайд халдсан байлаа. Бид шатан дээр автобус хүлээж байх үед нөгөө залуу маань илүү том, илүү чанга дуутай, илүү ууртай найздаа намайг юу хийж орхисныг хэллээ. Тэр эр над дээр ирээд “Чам дээр өнөө шөнө очтол намайг хүлээ цагаан арьстан минь. Чамаас өмхий үнэртэж байна. Би хэзээ ч ийм олиггүй үнэр урьд үнэртэж байсангүй. Чи ширээн дээр хөлөө тавьснаараа наад өмхийгөө тараасан байна. Чи тэнд очмогцоо шүршүүрт орсон чинь дээр байх, гэхдээ энэ чамайг аврахгүй. Тэгээд цагаанаа автобус дотор миний болон найзын минь ойролцоо суусны хэрэггүй шүү. “Би юу ч хариулсангүй. Үйл явдал бид автобусанд суухад үргэлжиллээ. Хэн ч намайг өмөөрч үг хэлсэнгүй. Хүмүүс намайг хажууд нь суух гэхэд хөөж байлаа. Миний үеийн нэг хар эр түүний хажууд суусанд харин хөөсөнгүй. Том эр дахиад хэсэг хугацаанд намайг сүрдүүлсэн юм, гэвч тэрээр удалгүй жолоочоос хэрхэн үнэмлэх авч болох талаар шалгааж эхэллээ. Магадгүй энэ эрийн хар тамхи гарч эхэлсэн байх.

Би айсан гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Би нэр, хаяг, ажлын утас зэргийг бичээд халаасандаа хийсэн байлаа. Ядаж л хэн нэгэн энэ заналхийлэл үнэн байсан бол хаашаа залгаа мэдэх байсан юм. Би энэ зүйл биелэлээ олсон бол өөрийгөө хамгаалж чадахгүйгээ ойлгож байлаа. Бид Уард Айландад орондоо орох гээд оочерлож байхад намайг занасан хүний талаар таагүй яриа хаа сайгүй байлаа, гэхдээ хэн ч түүнд шууд хэлж зүрхэлсэнгүй. Би тавгүй унтсан тэр шөнө. Би нүүрээ нуун худал ярих дургүй.

### **Баасан гараг, 1/28**

Би босоод Кийнэрээс аль болох эрт гарлаа. Би үлдсэн жаахан мөнгөөрөө хотын автобусанд сууж Манхэттэн оров. Зүүн 3-р гудамжинд өглөөний ундаа уугаад, олон нийтийн хоргодох байрнаас салахад бэлэн болсон байв. Мэдээж өглөө хүйтэн байсан. Би 3-р гудамжны том эрийн тухай ой санамжаа Фүлтон загасны дэлгүүрээр хэсэнгээ арилгалаа. Би Бруклиний гүүрийг гатлахдаа дуулж байгаагаа анзаараад өөрийгөө хичнээн тайван эрх чөлөөтэй буйг мэдлээ. Аяга кофе, Таймс сонин 2 гартаа аваад голын эрэг дээр суугаад сонингоо уншлаа. Би Уолл Стрийтээр тэнүүчилж зарим гудамжны байрлалыг бараг л цээжлэв. 15-р гудамжны Рутерфордын сүмийн уулзалтын байшингийн хавиар явж байгаад үүдэнд нь байгаа “Хүн бүхний дотор бурхан бий” гэсэн үг өчигдөр миний учирсан болон өнгөрсөн 10 өдөрт тааралдсан хэд хэдэн хүнд зориулагдаж болохыг ойлгов. Би энэ үгэнд итгэж байсан ч яаж гэдгийг харах нь надад хэцүү байлаа. Харанхуй боллоо. Би өнөөдөр автобусны буудал, Гранд цэнтрал 2-с хөөгдлөө. Би Пэнний буудлаас өөрийн энгийн хувцсаа авч эрчүүдийн өрөөнд солилоо, тэгээд АА галт тэргэнд сууж гэрийн зүг хөдлөв. Орж ирэхэд байр минь дулаан, ор минь цэвэрхэн байлаа. Ингээд л бүх зүйл ард хоцорлоо.